Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,152,092,050.70 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 23,802,306,53 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагч нь байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, бүтэц орон тоог оновчтой төлөвлөж, хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан ажилласан байна.

Байгууллага хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласнаар зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж 158,096.05 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих орлого, зардлын 149 мэдээллийг ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

- Багахангай дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийт 2,027,621.3 мянган төгрөгийн орлогын 10 гүйлгээ, зарлагын 10 гүйлгээний мэдээлэл мэдээллээгүй байна.
- Багануур дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийт ил тод байршуулбал зохих 149 мэдээллээс 4 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан байна.
- Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийт 104,282.2 мянган төгрөгийн 3 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.
- Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь "Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг 2 удаа хугацаа хоцроон мэдээллэсэн байна.
- Сонгинохайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 75,686.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.
- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зардлын мөнгөн гүйлгээний 15,693 удаагийн нийт 1,817,247,737.5 мянган төгрөгийн гүйлгээг 9,088,325,060.1 мянган төгрөгөөр буюу 7,271,077,322.6 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.
- Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь " Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" -ийн 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

_Шийдвэрлэсэн нь_:
Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгч, 2 албан шаардлага хүргүүлсэн.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- **Дансны авлагын талаар**

Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 15.0 хувиар бууруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр авлагын үлдэгдэл оны эхнээс 3.0 хувиар буюу 1,783,232.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:
Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулж ажиллах зөвлөмж өгөв.

- **Орлогын төлөвлөгөөний талаар**

Сайн дурын даатгалын шимтгэлийн орлогыг 872,697.0 мянган төгрөг, бусад орлогыг 598,626.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалаас санхүүжих орлогыг 27,036.6 мянган төгрөг, хүүхэд асрах хугацааны даатгалын орлогыг 70,937.5 мянган төгрөг, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлсөн шимтгэлийн орлогыг 17,624.1 мянган төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна. Энэ ньТөсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй.

*Шийдвэрлэсэн нь*:
Батлагдсан төлөвлөгөөг биелүүлж ажиллах зөвлөмж өгөв.

- **Зардлын гүйцэтгэлийн талаар**

Сан хооронд 1,082,230.1 мянган төгрөгийг шилжүүлж, ажилгүйдлийн тэтгэмжийн сангийн зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлсэн байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 “ Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно.” Заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:
Батлагдсан зардлыг хуваарийн дагуу зарцуулах зөвлөмж өгөв.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 7,246,885.2 мянган төгрөгийн 25 алдаа зөрчил илэрч, зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 1,487,961.10 мянган төгрөгийн 21 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, 47,089.40 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 5,707,720.40 мянган төгрөгийн 2 алдаа хэрэгжээгүй байна.

Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэсийн завсрын аудитаар 5,707,720.40 мянган төгрөгийн алдаа биелээгүй гэсэн боловч жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэлээр 905,036.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1,705.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 223,007,731.31 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 21 албан шаардлагыг 71.0 хувь, 3,991,162.10 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 26 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 1,705.00 | 2 | 1,705.00 | 100% |
| АШ | 21 | 223,007,731.31 | 15 | 219,937,589.21 | 71% |
| Зөвлөмж | 26 | 3,991,162.10 | 23 | 2,011,533.10 | 88% |
| **Нийт дүн** | **49** | **227,000,598.41** | **40** | **221,950,827.31** | **82%** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Багануур дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст шүүхийн байгууллагаар шийдвэрлэсэн авлага барагдуулах гүйцэтгэлийн ажиллагааны хэрэгжилтийг хянах
- Багануур дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст авлага өмнөх оноос 1,516,549.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 12,918,487.8 мянган төгрөгт хүрсэн. Нийт авлагын 94.1 хувь буюу 12,157,767.2 мянган төгрөгийн " Багануур" ХК-аас авах авлага төлөгдсөн эсэх
- Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст авлага өмнөх оноос 9,908,675.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын 3.2 хувь буюу 1,110,626.0 мянган төгрөгийн авлага шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдсэн ч эргэн төлөлт хангалтгүй хийгдсэн тул авлага цуглуулах ажиллагаа идэвхижүүлсэн, арга хэмжээ авсан эсэх
- Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй, нэгэнт эдийн засгийн үр өгөөжгүй нь нотлогдсон,

төсвийн үр ашиггүй зардал гаргаж буй автомашинуудыг балансаас балансад шилжүүлэхгүй байх, актлах, дахин үнэлэх, худалдах асуудлыг холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлэх нь зүйтэй.

- Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангийн санхүүгийн программ хангамжийг 2006 оноос ашиглаж байгаа бөгөөд энэ нь зарим журнал, дэлгэрэнгүй бүртгэл, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн харьцуулсан мэдээллүүд боловсруулагддаггүй, санхүүгийн тайлангийн программаас аудитын шаардлагатай загварын дагуу мэдээллүүд хөрвүүлэгдэхгүй байгаад анхаарч программ хангамжийг сайжруулах шаардлагатай байна.
- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг барагдуулаагүйн улмаас харилцах данс нь хаагдсан 1116 байгууллагын 26,748,778.6 мянган төгрөгийн, үйл ажиллагаа нь зогссон 46 байгууллагын 22,773.6 мянган төгрөгийн, нийт 26,771,552.1 мянган төгрөгийн найдваргүй авлагын үлдэгдлийг төлбөртэй үйлчилгээний авлагаар тайлагнасан нь хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байна. Иймд энэ асуудлыг дээд шатны байгууллагадаа уламжлан найдваргүй авлагын нөөц байгуулан шийдвэрлүүлэх
- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын сангийн бус орлого төвлөрүүлэх арилжааны 5, төрийн сангийн 1, нийт 6 харилцах данс дахь 723,857.8 мянган төгрөгийн мөнгөн төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг холбогдох сангуудад тогтоосон хэмжээгээр хуваарилаагүйг, сан хооронд шилжүүлсэн зардлыг, нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийн сайжруулалтыг тус тус анхаарах нь зүйтэй байна.
- Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь НДЕГ-ын Мэдээлэл тооцоолох төвийн 2007 онд боловсруулсан программуудыг ашиглаж байгаа бөгөөд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд "Sanhuu ins", "Hariltsah" гэсэн 2 программ ашиглаж байна. Уг программууд нь өмнөх үеийн мэдээлэл татагддаггүй, судалгаа шинжилгээ хийгддэггүй, тоон мэдээлэл алдаатай татагддаг, гар ажиллагаа ихтэй зэрэг дутагдалтай талууд ажиглагдлаа. Тус программ нь Сангийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 47 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ыг хангахгүй байгаа тул ННДГ болон НДЕГ-ын удирдлагын анхааралд хандуулан нэн яаралтай засаж, сайжруулах шаардлагатай байна гэж үзсэн ба нийт НДЕГ-аас 2022-2023 онд программын шинэчлэлтийг туршилтын хүрээнд хийж байна.
- Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь 2006 оны 18/03 дугаар тушаалаар баталсан “НДСанд хэрэгжүүлэх НББ-ийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал”-ыг хүчингүй болгоогүй. 2018 онд НДЕГ-аас шинэчлэн боловсруулсан НБББББ-ийг баталсан шийдвэр гараагүй, мөрдөж эхлэх хугацаа нь тодорхойгүй мөн уг баримт бичгийн “Үндсэн хөрөнгийн бодлого горим”-ын 7.5.8-д “Нийгмийн даатгалын байгууллагын өмчлөлд байгаа үндсэн хөрөнгийн тогтоосон ашиглалтын хугацааг Нийгмийн даатгалын төв байгууллагын удирдлагаас баталсан “Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах журам”-д заасны дагуу тодорхойлно” гэж заасан боловч

НДЕГ-аас тусгайлан журам боловсруулан мөрдүүлээгүй, үндсэн хөрөнгийн төрөл зүйл, ашиглалтын жил, элэгдлийн хувь хэмжээг тогтоож өгөөгүй байгаа тул дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

Дээрх дүүргүүдийн дараагийн аудитаар анхаарах асуудалд санхүүгийн программын асуудал, мөн авлагын асуудлыг үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар Нийслэлийн 9 дүүрэг, нийслэлийн нийгмийн даатгалын газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд нийт 309,380.6 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс, аудитын явцад 309,380.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Сонгино хайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан бараа ажил үйлчилгээнд и баримт шивэгдээгүй 6,465.70 мянган төгрөгийн гүйлгээнд нөхөн баримтыг шивүүлж алдааг залруулсан.
- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын тайланд 14 ажилтны цалин хөлсийг 1,409.3 мянган төгрөгөөр дутуу, 7 ажилтны 912.0 мянган төгрөгөөр илүү, нийт 2,321.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.
- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн хувь хүний орлогын албан татварын цахим тайланд 7 ажилтны цалин хөлсийг 1,647.2 мянган төгрөгөөр дутуу, 2 ажилтныг 520.1 мянган төгрөгөөр илүү, нийт 2,167.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан
- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэний хөдөлмөрийн хөлснөөс 1,803.4 мянган төгрөгийн татварыг илүү суутгасаныг залруулсан.
- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн цалин, хөлс түүнтэй адилтгах орлогыг 38.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.
- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, зардлыг 9,938.2 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан.
- 2022 оны САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН-ийн Багануур дүүргийн Бараа материал дансны сэлбэг хэрэгсэлд тайлагнах 678.0 мянган төгрөгийг түлш тослох материалд буюу эдийн засгийн ангилал буруу тайлагнасан.
- 2021 оны Чингэлтэй дүүргийн төрийн сангийн харилцах үлдэгдэл 2021 оны аудитлагдсан тайлантай 7,818.0 мянган төгрөгөөр зөрсөн.
- Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс санхүү байдлын тайланд биет бус хөрөнгийг элэгдлээрээ өртөгөө нөхсөн хөрөнгийг бүртгэсэн байна.
- 2022 оны САНХҮҮ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН-ийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалийн сангаас санхүүжих дүнг 7,297.4 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.
- 2022 оны МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН Багахангай дүүргийн урсгал шилжүүлгийн аудитлагдсан тайлангийн дүн 133.8 мянган төгрөг,
- Багануур дүүргийн 2022 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын дүн 183.5 мянган төгрөгийн дүнг тайлагнаагүй
- Налайх дүүргийн 2021 оны мөнгөн гүйлгээний аудитлагдсан тайлангийн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн дүнг 270,535.9 мянган төгрөгөөр тоог андуурч буруу тайлагнасан.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 1,904,638.30 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 1,809,560.30 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 95,078.00 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

## 5.2 Албан шаардлага

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 8 зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

- Багахангай дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь худалдан авалтын 520.0 мянган төгрөгийн дүнг ибаримтаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

- Сонгино хайрхан дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь тайланд онд 1,000.0 мянган төгрөгийн сургалтын зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Холбогдох зардлын санхүүжилтийг хэмнэж ажиллах, Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст нь НДЕГ-ын даргын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/22 тоот тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан " Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн орон тоог 8 орон тоогоор илүү ажиллуулж, 44,012.8 мянган төгрөгийн цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 " Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Шийдвэрлэсэн нь*: Холбогдох зардлын санхүүжилтийг хэмнэж ажиллах, Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

- Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн тайлангийн засгийн газрын болон бусад шатны байгууллагад төлөх өглөг өмнөх оноос 838,431.1 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

- Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс 36 албан хаагчид 5,710.0 мянган төгрөг, 2022 оны жилийн эцэст 42 албан хаагчид 10,200.0 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна. Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дах хэсэгт "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; " гэж заасныг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2019 оны Төрийн албан хаагчийн нөхөн төлбөр олгох журмын 8 заалтыг хэрэгжүүлэн ажиллах. Тэтгэмж, урамшууллыг хавтгайруулах, олгохгүй байх гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

- Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь Өндөр насжилттай авлагаас 369 харилцагчийн 905,036.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8. "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", НББ-ийн тухай хуулийн Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэгтэй:", 20.2.5."дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах; зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

- Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь Тайлант хугацаанд танхимын сургалт зохион байгуулж, 2,500.0 мянган төгрөгийн сургалт, семинарын зардал гаргасан байна. Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дах хэсэгт "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, цаашид аливаа сургалт, семинарыг цахим хэлбэрээр зохион байгуулах гэсэн заалтыг зөрчиж байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

- Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь Төрийн сангийн харилцахын гүйлгээг анхан шатны баримт руу хөөн шалгаж үзэхэд даатгуулагчдын мэдээллээр тасралтгүй хангах үүднээс Рарэ Колор ХХК-руу 2,150.0 мянган төгрөгийн брошур, анонсын хэвлэлтийн зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дах хэсэгт заасны дагуу төсвийн байгууллага "Хэвлэл захиалгын төлбөр санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, сургалт, семинарыг цахим хэлбэрээр зохион байгуулж хэвлэл, бичиг хэргийн зардлыг хэмнэх гэсэн заалттай нийцээгүй.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Авлагын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт-1:* Баянгол дүүргийн нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд авсан орон сууцыг 1 иргэний эзэмшилд 2003 онд шилжүүлсэнээр 10,780.0 мянган төгрөгийн авлага үүсэж, бусад авлага дансанд бүртгэгдсэн уг авлагыг шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 " төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 " дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ..." заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

*Өгсөн зөвлөмж*: Он дамжсан хугацаа хэтэрсэн авлагыг холбогдох эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх

*Илрүүлэлт-2:* Багануур дүүргийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өмнөх оноос 5,010,536.0 мянган төгрөгөөр өссөн. Нийт авлагын 94.1 хувь буюу 12,157,767.2 мянган төгрөг нь "Багануур" ХК-аас авах авлага байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 "дансны авлага, өр төлбөрийн тооцоог хянах, ..." заалт, 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтууд нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Авлагыг барагдуулах шат дараатай арга хэмжээ авах, төсвийг зохистой удирдаж, авлага үүсгэхгүй байх

*Илрүүлэлт-3:* Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын үлдэгдэл НДЕГ-аас баталсан ажлын төлөвлөгөөнд "нийт төлбөртэй үйлчилгээний шимтгэлийн орлогын 10.0 хувиас хэтрэхгүй байх" гэж заасан, нийгмийн даатгалын авлага өмнөх оноос 9,908,674.5 мянган төгрөгөөр өссөн. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын 3.2 хувь буюу 1,110,626.0 мянган төгрөг нь шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдсэн ч эргэн төлөлт хангалтгүй, арга хэмжээ авагдаагүй байна. Авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулж ажиллаагүйгээс авлагын өсөлт жил бүр өсөн нэмэгдэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 "дансны авлага, өр төлбөрийн тооцоог хянах, ..." заалт, 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалтууд нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Авлагыг барагдуулах шат дараатай арга хэмжээ авах, төсвийг зохистой удирдаж, авлага үүсгэхгүй байх

## 2. Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт-4:* Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн засварын ажлын үр дүнг хүлээлцсэн акт баталгаажаагүй байхад үлдэгдэл төлбөрийн 14,250.0 мянган төгрөгийг тухайн байгууллагад шилжүүлсэн байна. Энэ нь Захиалагч, гүйцэтгэгч талуудын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр байгуулсан гэрээний 3.3 "Ажил гүйцэтгэгч нь гүйцэтгэвэл зохих нийт ажил үйлчилгээг бүрэн гүйцэтгэж Захиалагчид ажлын үр дүнг хүлээлгэн өгч тайлагнах бөгөөд Захиалагч ажлын үр дүнг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор ажил үйлчилгээний төлбөрийг ажил гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ" заалтыг хэрэгжүүлээгүй, "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

*Өгсөн зөвлөмж*: Анхан шатны иж бүрэн баримтаар нотлогдсон тохиолдолд зардал гаргах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллах

*Илрүүлэлт-5:* Хан Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 821.7 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийж бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно," заалттай нийцээгүй.

*Өгсөн зөвлөмж*: Анхан шатны иж бүрэн баримтаар нотлогдоогүй тохиолдолд ажил гүйлгээг бүртгэхгүй байх

*Илрүүлэлт-6*: Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь НДЕГ-ын даргын 2022 оны 12-р сарын 30-ны өдрийн А/193 тоот тушаалаар 12,150.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 2014 онд ашиглалтанд орсон Хьюндай элентра маркийн 55-16УАВ улсын дугаартай суудлын автомашиныг балансаас балансад шилжиж ирсэн.

Тус автомашин нь ашиглалтын шаардлага хангахгүйгээс тайланд онд 3,134.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл авч урсгал засвар хийжээ. Тус байгууллагад ашиглалтын шаардлага хангахгүй 2 автомашин бүртгэлтэй байгаа нь жил бүр урсгал засвар үйлчилгээ хийгдэж, төсвийн үргүй зардал гарах үндэслэл болж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

*__Өгсөн зөвлөмж__*: Байгууллагын үйл ажиллагаанд цаашид ашиглах боломжгүй автомашины асуудлыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх

*__Илрүүлэлт-7__:* Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн Шатахууны нярав анхан шатны баримтын мэдээллийг алдаатай хөтөлснөөс үүдэн шатахууны зардлын норм хэтрэлттэй мэт харагдаж явсан км-н хэмжээг буруу илэрхийлсэн байна.Өөрөөр хэлбэл нярав жолоочийн тооцооны замын хуудсыг нэгтгэхдээ явсан километрийг үндэслэлгүйгээр буруу нэгтгэсэн нь шатахууны зардалд тавих хяналт сул байгааг харуулж байгаа бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйл 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", гэсэн заалтуудын дагуу анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байна.

*__Өгсөн зөвлөмж__*: Анхан шатны баримтыг үнэн зөв мөн иж бүрэн бүрдүүлж байх.

*__Илрүүлэлт-8__*: Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн Дээд шатны төсвийн захирагчаас нийгмийн даатгалын байгууллагууд ард иргэдэд тасралтгүй үйл ажиллагаагаа хангах шаардлагатай гэж үзэн тээврийн хэрэгслийг ТӨБЗГазраас автобааз руу шилжүүлээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу төсвийн байгууллагын дарга хот дотор автомашин ашиглахыг хориглоно. 6.2-т бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно, автомашинтай холбогдон гарах урсгал засвар, даатгалын зардал гэх мэт зардлыг хэмнэнэ гэж заасныг зөрчсөн байна.

*__Өгсөн зөвлөмж__*: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.2-т 'Төсвийн байгууллагын дарга хот дотор автомашин ашиглахыг хориглоно' гэсэн заалтыг мөрдөх.

*__Илрүүлэлт-9__:* Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн Бүртгэлтэй автомашин нь энгийн улсын дугаартай байгаа нь Төрийн хэмнэлтийн хуулийн 6.4-т зааснаар Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ гэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төрийн хэмнэлтийн хуулийн 6-р зүйл 6.4 “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэсэн заалтыг мөрдөх

*Илрүүлэлт-10*: Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь Элентра маркийн 13-32УНҮ дугаартай суудлын автомашиныг ашиглаж, нийт 7,403.7 мянгн төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуй нэгж, эсхүл төрийн боло орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно.” Гэсэн заалттай УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах,

**3. Өглөгийн данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт-11:* Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн урьдчилж орсон орлого дансанд байгууллагын нэр тодорхойгүй бусад нэрээр ангилан бүртгэсэн 47,089.4 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 “дансны авлага, өр төлбөрийн тооцоог хянах, ...” заалт, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй.

*Өгсөн зөвлөмж*: Өр төлбөр үүссэн шалтгааныг тодорхойлж, шат дараатай арга хэмжээ авч ажиллах

**4. Худалдан авалттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт-12:* Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн нийт 6 байгууллагатай холбоотой 4,686.1 мянган төгрөгийн худалдан авалт И баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалт, ” Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн

даруй мэдэгдэх үүрэгтэй" УСНББОУС-ын үндсэн шаардлага, "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

*Өгсөн зөвлөмж*: Худалдан авалт хийх бүрд И баримтаар баталгаажуулж байх,

*Илрүүлэлт-13:* Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс тайланд онд худалдан авалтын 1,844.0 мянган төгрөгийн худалдан авалт И баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" УСНББОУС-ын үндсэн шаардлага, "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

*Өгсөн зөвлөмж*: Худалдан авалт хийх бүрд И баримтаар баталгаажуулж байх,

**5. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт-14:*

- Баянгол дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс үндсэн хөрөнгийн дансанд хуримтлуулагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 7 ширхэг 4,308.4 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.
- Багануур дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, анхны өртгөө бүрэн нөхсөн 2 нэрийн 2,098.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Тооллогын бүртгэлээр тус хөрөнгүүдийн чанар байдлыг тодорхойлоогүй байна.
- Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, анхны өртгөө бүрэн нөхсөн 3 нэрийн 8 ширхэг 6,350.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Тооллогын бүртгэлээр тус хөрөнгүүдийн чанар байдлыг тодорхойлоогүй байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2 " Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1

" элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон" заалт, УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-д тавигдах шаардлага, үнэлгээ ба хуваарьлалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй.

*__Өгсөн зөвлөмж__*: Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоож, холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх,

*__Илрүүлэлт-15:__* Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 5 ширхэг 2,008.0 мянган төгрөгийн дүнтэй үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 344.9 мянган төгрөгөөр дутуу тооцож бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл.Нягтлан бодох бүртгэлийн стандарт 4.1.3 "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт."-ыг мөрдөнө гэж заасны дагуу УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө "Үндсэн хөрөнгө"-ийн 39 дугаар зүйлд "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт байдлаар тайлагнана."гэж заасантай нийцэхгүй байна

*__Өгсөн зөвлөмж:__* УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн стандартын дагуу элэгдлийн зардлыг жил бүрийн эцэст давтан шалгаж байх, элэгдүүлэх жилийг УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө 38-р зүйлд "Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна" гэж заасны дагуу тооцон элэгдүүлж байх шаардлагатай.

**6. Программ хангамжтай холбоотой асуудал**

*__Илрүүлэлт-16:__* Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ Дижитал Воркс ХХК-ийн бэлтгэсэн Greem Finance-Gov 2.0 программыг ашиглаж байна. Уг программ хангамж нь Сангийн сайдын 2014 оны 5, 2015 оны 07, 55, 388 дугаар тушаалуудаар баталсан маягт аргачлалын дагуу аккурэл суурьт шалгах баланс тодруулгууд, тохируулах бичилтүүдийг бэлтгэхгүй байна.

*__Өгсөн зөвлөмж:__* Программ хангамж нийлүүлэгч компаниар холбогдох сайжруулалтыг хийлгүүлэх,

**7. Нийгмийн даатгалын сангийн орлоготой холбоотой асуудал**

*__Илрүүлэлт-17:__* Нийгмийн даатгалын сангийн мөнгөн орлогыг хуульд заасан хувиар бус дараа сарын тухайн сангийн тэтгэвэр тэтгэмжийг тасалдуулахгүй олгох шаардлагатай уялдуулан хуваарилсанаар даатгалын сангуудын мөнгөн орлогын дүнг хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнээс зөрүүтэй тайлагнаж байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15-р зүйлийн 1 заасан Ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувьтай нийцэхгүй байна.

*__Өгсөн зөвлөмж:__* Тухайн саруудад тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг тооцоолон хуваарилж болох ч жилийн эцсийн үр дүнд хуульд заасан хувийг баримтлах хэрэгтэй

гэж үзэн цаашид энэ тал анхаарах хэрэгтэй гэж үзэж байна. НББББ-т Нийгмийн даатгалын сангуудын орлогыг хэрхэн хуваарилах талаар тусгах, НДЕГ-ын даргын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/121 тоот тушаал нь Нийгмийн даатгалын мөнгөн хөрөнгийн урсгалыг зохицуулсан тушаал учраас цаашдаа сангийн орлогыг хуваарилахдаа хуульд заасан хувийг баримтлах талаар төсвийн дээд шатны захирагчийн хүрээнд зохицуулах нь зүйтэй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Дүүрэг | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| СХД | Бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан бараа ажил үйлчилгээнд и баримт шивэгдээгүй | 1 | 6,465.70 | | | 1 | 6,465.70 | 1 | 6,465.70 | | | | |
| СБД | Нийгмийн даатгалын тайланд 14 ажилтны цалин хөлсийг 1,409.3 мянган төгрөгөөр дутуу, 7 ажилтны 912.0 мянган төгрөгөөр илүү, нийт 2,321.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 2321.3 | | | 1 | 2321.3 | 1 | 2321.3 | | | | |
| СБД | Хувь хүний орлогын албан татварын цахим тайланд 7 ажилтны цалин хөлсийг 1,647.2 мянган төгрөгөөр дутуу, 2 ажилтныг 520.1 мянган төгрөгөөр илүү, нийт 2,167.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 2167.2 | | | 1 | 2167.2 | 1 | 2167.2 | | | | |
| СБД | Хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэний хөдөлмөрийн хөлснөөс 1,803.4 мянган төгрөгийн татварыг илүү суутгасаныг залруулсан. | 1 | 1803.4 | | | 1 | 1803.4 | 1 | 1803.4 | | | | |
| СБД | Цалин, хөлс түүнтэй адилтгах орлогыг 38.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон | 1 | 38.2 | | | 1 | 38.2 | 1 | 38.2 | | | | |
| СБД | Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, зардлыг 9,938.2 мянган төгрөгөөр бууруулж тайлагнасан. | 1 | 9,938.20 | | | 1 | 9,938.20 | 1 | 9,938.20 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэгтгэсэн тайлан | 2022 оны САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН-ийн Багануур дүүргийн Бараа материал дансны сэлбэг хэрэгсэлд тайлагнах 678.0 мянган төгрөгийг түлш тослох материалд буюу эдийн засгийн ангилал буруу тайлагнасан. | 1 | 678.00 | | | 1 | 678.00 | 1 | 678.00 | | | | |
| Нэгтгэсэн тайлан | 2021 оны Чингэлтэй дүүргийн төрийн сангийн харилцах үлдэгдэл 2021 оны аудитлагдсан тайлантай 7,818.0 мянган төгрөгөөр зөрсөн. | 1 | 7,818.00 | | | 1 | 7,818.00 | 1 | 7,818.00 | | | | |
| Нэгтгэсэн тайлан | Налайх дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс санхүү байдлын тайланд биет бус хөрөнгийг элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг бүртгэсэн байна | 1 | 0.00 | | | 1 | 0.00 | 1 | 0.00 | | | | |
| Нэгтгэсэн тайлан | 2022 оны САНХҮҮ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН-ийн Багануур дүүргийн Нийгмийн даатгалийн сангаас санхүүжих дүнг 7,297.4 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. | 1 | 7,297.40 | | | 1 | 7,297.40 | 1 | 7,297.40 | | | | |
| Нэгтгэсэн тайлан | 2022 оны МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН Багахангай дүүргийн урсгал шилжүүлгийн аудитлагдсан тайлангийн дүн 133.8 мянган төгрөг | 1 | 133.80 | | | 1 | 133.80 | 1 | 133.80 | | | | |
| Нэгтгэсэн тайлан | Багануур дүүргийн 2022 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын дүн 183.5 мянган төгрөгийн дүнг тайлагнаагүй. | 1 | 183.50 | | | 1 | 183.50 | 1 | 183.50 | | | | |
| Нэгтгэсэн тайлан | Налайх дүүргийн 2021 оны мөнгөн гүйлгээний аудитлагдсан тайлангийн ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн дүнг 270,535.9 мянган төгрөгөөр буруу тайлагнасан. | 1 | 270,535.90 | | | 1 | 270,535.90 | 1 | 270,535.90 | | | | |
| | | **13.0** | **309,380.60** | | | **13.00** | **309,380.60** | **13.00** | **309,380.60** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Дүүрэг | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| БГД | Он дамжсан авлагыг барагдуулаагүй, шийдвэрлээгүй | 1 | 10,780.00 | | | | | 1 | 10,780.00 | | | | |
| БГД | Гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй төлбөрийг шилжүүлсэн | 1 | 14,250.00 | | | | | 1 | 14,250.00 | | | | |
| БГД | Бусад нэрээр ангилсан өртөг бүртгэгдсэн | 1 | 47,089.40 | | | | | 1 | 47,089.40 | | | | |
| БГД | Худалдан авалтын ибаримтаар баталгаажуулаагүй | 1 | 4,686.10 | | | | | 1 | 4,686.10 | | | | |
| БГД | Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлээгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| БГД | Суудлын автомашин ашиглаж зардал гаргасан | 1 | 7,403.70 | | | | | 1 | 7,403.70 | | | | |
| БХД | Худалдан авалтын ибаримтаар баталгаажуулаагүй | 1 | 520.00 | | | 1 | 520.00 | | | | | | |
| БНД | 2022 оны санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, одоо ашиглагдаж байгаа 2 нэрийн 2,098.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| БНД | НДШ-ийн авлага өмнөх оноос 1,516,549.1 мянган төгрөгөөр өссөн байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| ЧД | 2022 оны санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, одоо ашиглагдаж байгаа 3 нэрийн, 8 ширхэг 6,350.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| ЧД | НДШ-ийн авлага өмнөх оноос 9,908,675.5 мянган төгрөгөөр өссөн, тайлант хугацаанд авлага барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| ХУД | Зардлын данстай холбоотой асуудал | 1 | 821.70 | | | | | 1 | 821.70 | | | | |
| НД | Худалдан авалтын ибаримтаар баталгаажуулаагүй | 1 | 1,844.00 | | | | | 1 | 1,844.00 | | | | |
| НД | Төсвийн үргүй зардал гарсан | 1 | 3,134.00 | | | | | 1 | 3,134.00 | | | | |
| СХД | Тайлант онд сургалтын зардал 1000.0 мянган төгрөг гаргасан. | 1 | 1,000.00 | | | 1 | 1,000.00 | | | | | | |
| СБД | Батлагдсан орон тоог 8 орон тоогоор илүү ажиллуулж, 44,012.8 мянган төгрөгийн цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг олгосон байна. | 1 | 44,012.80 | | | 1 | 44,012.80 | | | | | | |
| СБД | Засгийн газрын болон бусад шатны байгууллагад төлөх өглөг 2,523,764.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 838,431.1 мянган төгрөгөөр өссөн байна. | 1 | 838,431.10 | | | 1 | 838,431.10 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| СБД | Байгууллагын ашиглаж буй Green Finance-Gov 2.0 программ хангамж нь Сангийн сайдын 2014 оны 5, 2015 оны 07,55, 388 дугаар тушаалуудаар баталсан маягт аргачлалын дагуу аккурэл суурьт шалгах баланс тодруулгууд, тохируулах бичилтүүдийг бэлтгэхгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| БЗД | Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс 15,910.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосонтой байна | 1 | 15,910.00 | | | 1 | 15,910.00 | | | | | | |
| БЗД | Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй нийт 5 ширхэг 2,008.0 мянган төгрөгийн дүнтэй үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 344.9 мянган төгрөгөөр дутуу тооцож бүртгэсэн байна | 1 | 344.90 | | | | | 1 | 344.90 | | | | |
| БЗД | Шатахууны нярав анхан шатны баримтын мэдээллийг алдаатай хөтөлснөөс үүдэн шатахууны зардлын норм хэтрэлттэй мэт харагдаж явсан км-н хэмжээг буруу илэрхийлсэн байна. | 1 | 1,538.60 | | | | | 1 | 1,538.60 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| БЗД | Нийгмийн даатгалын сангийн мөнгөн орлогыг хуульд заасан хувиар бус дараа сарын тухайн сангийн тэтгэвэр тэтгэмжийг тасалдуулахгүй олгох шаардлагатай уялдуулан хуваарилснаар даатгалын сангуудын мөнгөн орлогын дүнг хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнээс зөрүүтэй тайлагнаж байна | 1 | - | | | | | 1 | | | | | |
| БЗД | Өндөр насжилттай авлагаас 369 харилцагчийн 905.03 сая төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ тайлант онд авч хэрэгжүүлээгүй байна. | 1 | 905,036.40 | | | 1 | 905,036.40 | | | | | | |
| БЗД | Автомашинтай холбогдон шатахууны зардал гаргасан байна. | 1 | 3,185.60 | | | | | 1 | 3,185.60 | | | | |
| БЗД | Бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байна. | 1 | - | | | | | 1 | | | | | |
| БЗД | Тайлант хугацаанд хэлтсийн албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сэдэвт танхимын сургалт зохион байгуулж, 2,500.0 мянган төгрөгийн сургалт, семинарын зардал гаргасан байна. | 1 | 2,500.00 | | | 1 | 2,500.00 | | | | | | |
| БЗД | 2,150.0 мянган төгрөгийн брошур, анонсын хэвлэлтийн зардал гаргасан байна. | 1 | 2,150.00 | | | 1 | 2,150.00 | | | | | | |
| | | **27.00** | **1,904,638.30** | | | **8.00** | **1,809,560.30** | **19.00** | **95,078.00** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Дүүрэг | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | |
| БХД | Шилэн дансны цахим хуудсанд орлогын 10 гүйлгээ, зарлагын 10 гүйлгээ мэдээлээгүй байна. | 1 | 2,027,621.30 | | | 1 | 2,027,621.30 | | |
| БНД | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих мэдээллээс 4 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан | 1 | - | | | | | 1 | |
| ЧД | Шилэн дансны цахим хуудаст 3 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан. | 1 | 104,282.20 | | | | | 1 | 104,282.20 |
| НД | Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг 2 удаа хугацаа хоцроож мэдээллэсэн | 1 | - | | | | | 1 | 0 |
| СХД | Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 75,686.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан. | 1 | 75,686.60 | | | | | 1 | 75,686.60 |
| СБД | Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зардлын мөнгөн гүйлгээний 15,693 удаагийн нийт 1,817,247,737.5 мянган төгрөгийн гүйлгээг 9,088,325,060.1 мянган төгрөгөөр буюу 7,271,077,322.6 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна. | 1 | - | | | 1 | - | | |
| ННДГ | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих мэдээллээс 1 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан | 1 | - | | | | | 1 | - |
| | Дүн | 7.00 | 2,207,590.10 | - | - | 2.00 | 2,027,621.30 | 5.00 | 179,968.80 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | |
| СБД | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 15 хувиар бууруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр авлагын үлдэгдэл оны эхнээс 3 хувиар буюу 1,783,232.8 мянган төгрөгөөр өссөн байна. | 1 | 1,783,232.80 | | | | | 1 | 1,783,232.80 |
| СБД | Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого 872,697.0 мянган төгрөг, бусад орлого 598,626.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалаас санхүүжих орлого 27,036.6 мянган төгрөг, хүүхэд асрах хугацааны 70,937.5 мянган төгрөг, ҮОМШӨДС-аас төлсөн шимтгэлийн орлого 17,624.1 мянган төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байна. | 1 | 17,624.10 | | | | | 1 | 17,624.10 |
| СБД | Ажилгүйдлийн тэтгэмжийн сангийн зардал 1,082,230.1 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтэрсэн байна. | 1 | 1,082,230.10 | | | | | 1 | 1,082,230.10 |
| | Дүн | 3.00 | 2,883,087.00 | - | - | - | - | 3.00 | 2,883,087.00 |
| | **Дүн** | **10.00** | **5,090,677.10** | **-** | **-** | **2.00** | **2,027,621.30** | **8.00** | **3,063,055.80** |